НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР

2026 III

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

# САРЫН ТАНИЛЦУУЛГА

## 2026 оны 3 дугаар сар

Улаанбаатар хот
2026 он

# АГУУЛГА


| | | |
|---|---|---|
| | Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2024-2026 он | 1 |
| | Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр | 2 |
| | Чингэлтэй дүүргийн өрх, хүн амын 2024 оны үндсэн үзүүлэлт | 2 |
| I | Эрүүл мэнд | 4 |
| II | Нийгмийн даатгал, халамж | 7 |
| III | Гэмт хэрэг | 10 |
| IV | Дүүргийн төсөв | 12 |
| V | Хэрэглээний үнэ | 15 |
| VI | Нийтийн аж ахуй | 18 |
| VII | Аюулгүй байдал | 19 |
| VIII | Төрийн бусад үйлчилгээ | 20 |
| IX | Аж үйлдвэр | 24 |
| X | Хөдөлмөр | 27 |

## ХҮСНЭГТ 1. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, дүүргээр

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2024 III | 2025 III | 2026 III |
|---|---|---|---|---|
| Шинээр төрсөн хүүхэд | Хүн | 469 ↓20.2 | 492 ↑4.9 | 424 ↓13.8 |
| Халдварт өвчнөөр өвчлөгчид | Хүн | 227 ↓9.9 | 264 ↑16.3 | 249 ↓5.7 |
| Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт) | Хувь | 0.8 ↓72.4 | 0.4 ↓50.0 | 1.5 ↑275 |
| Дүүргийн төсвийн орлого | Тэрбум төгрөг | 52.4 ↑15.2 | 58.1 ↑10.9 | 64.9 ↑11.7 |
| Дүүргийн төсвийн зарлага | Тэрбум төгрөг | 28.3 ↓31.5 | 57.6 ↑103.5 | 43.6 ↓24.3 |
| Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, сарын эцэст | 1US$ =₮ | 3 375.9 ↓3.1 | 3 488.5 ↑3.3 | 3 573.7 ↑2.4 |

## ХҮСНЭГТ 2. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН 2025 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

| Дүүргийн дүн | Өрхийн тоо | Хүн амын тоо | Өрхийн дундаж ам бүлийн тоо[1] | Хүн ам зүйн ачаалал[2] |
|---|---|---|---|---|
| | 36 782 | 129 116 | 3.5 | 56.1 |
| 1 -р хороо | 847 | 3 197 | 3.8 | 65.4 |
| 2 -р хороо | 962 | 3 177 | 3.3 | 64.1 |
| 3 -р хороо | 1 541 | 5 405 | 3.8 | 62.4 |
| 4 -р хороо | 1 237 | 4 874 | 3.9 | 57.4 |
| 5 -р хороо | 1 180 | 4 441 | 3.8 | 58.0 |
| 6 -р хороо | 2 489 | 9 084 | 3.6 | 63.6 |
| 7 -р хороо | 1 807 | 5 984 | 3.3 | 52.2 |
| 8 -р хороо | 863 | 2 998 | 3.5 | 49.8 |
| 9 -р хороо | 1 489 | 5 267 | 3.5 | 51.0 |
| 10 -р хороо | 1 981 | 7 325 | 3.7 | 56.9 |
| 11 -р хороо | 1 176 | 4 189 | 3.6 | 51.2 |
| 12 -р хороо | 1 529 | 5 372 | 3.5 | 53.4 |
| 13 -р хороо | 1 743 | 6 397 | 3.7 | 57.1 |
| 14 -р хороо | 1 559 | 5 150 | 3.3 | 53.5 |
| 15 -р хороо | 2 060 | 7 358 | 3.6 | 54.6 |
| 16 -р хороо | 2 030 | 7 393 | 3.6 | 58.0 |
| 17 -р хороо | 2 161 | 7 059 | 3.3 | 53.9 |
| 18 -р хороо | 1 570 | 5 758 | 3.7 | 49.2 |
| 19 -р хороо | 2 061 | 6 857 | 3.3 | 52.3 |
| 20-р хороо | 1 274 | 4 268 | 3.4 | 53.4 |
| 21-р хороо | 1 893 | 6 993 | 3.7 | 57.5 |
| 22-р хороо | 1 184 | 4 035 | 3.4 | 56.0 |
| 23 -р хороо | 1 218 | 3 945 | 3.2 | 59.5 |
| 24 -р хороо | 928 | 2 590 | 3.8 | 60.5 |

1 Нэг өрхөд ногдох ам бүлийн дундаж тоо
2 Нэг километр квадрат газар нутагт ногдох хүний тоо

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

| | |
|---|---|
| - | гүйцэтгэл байхгүй |
| * | урьдчилсан гүйцэтгэл |
| ** | дахин |

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.
/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/




V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.
/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

| | |
|---|---|
| мянга | =1000 |
| сая | $=10^{6}$ |
| тэрум | $=10^{9}$ |
| их аяд | $=10^{12}$ |
| мян | мянга |
| % | хувь |
| мм | миллиметр |
| см | сантиметр |
| дм | дециметр |
| м | метр |
| км | километр |
| $м^{2}$ | метр квадрат |
| $дм^{2}$ | дециметр квадрат |
| $км^{2}$ | километр квадрат |
| $м^{3}$ | метр куб |
| га | гектар |
| мл | миллилитр |
| л | литр |
| г | грамм |
| кг | килограмм |
| цн | центнер |
| т | тонн |
| Вт | ватт |
| кВт.ц | киловатт цаг |
| кал | калори |
| ккал | килокалори |
| Гкал | гигакалори(=$10^{9}$ калори) |
| с | секунд |
| мин | минут |
| $мкг/м^{3}$ | микрограмм метр куб |
| м/с | метр секунд |
| ш | ширхэг |
| х.д.х | хэвлэлийн даралтат хуудас |

МЭДЭЭЛЭЛ

МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ

# ЭРҮҮЛ МЭНД

I-XII/2026 Тархаасан: 2026 оны 04 дүгээр сарын 15

## 2026 оны эхний 3 сард 421 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 72 (14.6%) төрөлтөөр буурсан байна.

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдээгээр 2026 оны эхний 3 сард 421 эх амаржиж, 424 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрсөн эх 72 (14.6%) мэндэлсэн хүүхэд 68 (13.8%) -иар тус тус буурсан байна.

**ХҮСНЭГТ 3.** **ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, 2026 оны эхний 3 сард**

| Үзүүлэлт | 2024 I-III | 2025 I-III | 2026 I-III | Өсөлт, бууралт 2025-2026 | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тоо | Хувь |
| Амаржсан эхийн тоо | 464 | 493 | 421 | -72 | -14.6 |
| Амьд төрсөн хүүхэд | 469 | 492 | 424 | -68 | -13.8 |
| Нас барсан хүн | 174 | 227 | 222 | -5 | -2.2 |
| Эхийн эндэгдэл | - | - | - | - | - |
| Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд | 3 | 7 | 6 | -1 | -14.3 |
| 1-5 настай хүүхдийн эндэгдэл | - | - | - | - | - |
| Амьгүй төрөлт | 4 | 6 | 1 | -5 | -83.3 |
| Гэрийн төрөлт | 4 | 1 | 2 | 1 | 100.0 |
| Хяналтгүй төрөлт | 5 | 4 | 4 | 0 | 0.0 |

** Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл*

**ЗУРАГ 1.** **АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, сараар**




2026 оны эхний 3 сард нийт 228616 удаа үзлэг хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 22701 (11.0%), эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 1745 болж өмнө оны мөн үетэй харьцуулахад 211 (13.8%) хүнээр өсжээ.

**ЗУРАГ 2.** **ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, сараар**




Бэлгийн замын халдварт өвчин 69 буюу нийт халдварт өвчний 27.7 хувийг эзэлж байна

**ХҮСНЭГТ 4.** **ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, 2026 оны эхний 3 сарын байдлаар**

| Төрөл | 2024 I-III | | 2025 I-III | | 2026 I-III | | 2026/2025 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бодит тоо | 10000 хүнд ногдох | Бодит тоо | 10000 хүнд ногдох | Бодит тоо | 10000 хүнд ногдох | Дүн | Хувь |
| **Дүүргийн дүн** | **227** | **16.2** | **264** | **18.8** | **249** | **18.5** | **-15** | -5.7 |
| Гепатит | 2 | 0.1 | 3 | 0.2 | 3 | 0.2 | 0 | 0.0 |
| Цусан суулга | 5 | 0.4 | 9 | 0.6 | 7 | 0.5 | -2 | -22.2 |
| Сальмоненнез | 4 | 0.3 | 2 | 0.1 | 1 | 0.1 | -1 | 50.0 |
| Хоолны хордлого | 0 | 0.0 | 0 | 0.0 | 4 | 0.3 | 4 | - |
| Менингококкт | 0 | 0.0 | 1 | 0.1 | 0.0 | 0.0 | -1 | 100.0 |
| Салхин цэцэг | 92 | 6.6 | 96 | 6.8 | 59 | 4.4 | -37 | -38.5 |
| Гахайн хавдар | 5 | 0.4 | 0 | 0.0 | 2 | 0.2 | 2 | - |
| Улаан эсэргэнэ | 8 | 0.6 | 10 | 0.7 | 13 | 1.0 | 3 | 30.0 |
| Ёлом | 3 | 0.2 | 3 | 0.2 | 3 | 0.2 | 0 | 0.0 |
| Бруцеллёз | 0 | 0.0 | 0 | 0.0 | 0 | 0.0 | 0 | - |
| Гар, хөл, ам | 10 | 0.7 | 8 | 0.6 | 13 | 1.0 | 5 | 62.5 |
| B34.1 Энтеровируст халдвар тодорхойгүй | 0 | 0.0 | 0 | 0.0 | 13 | 1.0 | 13 | - |
| Эритема | 0 | 0.0 | 4 | 0.3 | 4 | 0.3 | 0 | - |
| Ковид-19 | 0 | 0.0 | 0 | 0.0 | 0 | 0.0 | 0 | - |
| Улаан бурхан | 0 | 0.0 | 25 | 1.8 | 15 | 1.1 | -10 | -40.0 |
| Халдварын гаралтай суулга | 0 | 0.0 | 1 | 0.1 | 0 | 0.0 | -1 | -100.0 |
| Бусад | 0 | 0.0 | 0 | 0.0 | 16 | 1.2 | 16 | - |
| Тэмбүү | 42 | 3.0 | 39 | 2.8 | 32 | 2.4 | -7 | -17.9 |
| Төрөлхийн тэмбүү | 0 | 0.0 | 0 | 0.0 | 0 | 0.0 | 0 | - |
| Заг хүйтэн | 7 | 0.5 | 9 | 0.6 | 6 | 0.5 | -3 | -33.3 |
| Сүрьеэ | 21 | 1.5 | 28 | 2.0 | 27 | 2.0 | -1 | -3.6 |
| Мөөгөнцөр | 4 | 0.3 | 4 | 0.3 | 8 | 0.6 | 4 | 100.0 |
| Трихомониаз | 24 | 1.7 | 22 | 1.6 | 23 | 1.7 | 1 | 4.5 |
| ХДХВ/ДОХ | 0 | 0.0 | 0 | 0.0 | 0 | 0 | 0 | - |

** Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл*

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

# НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

I-XII/2025 Тархаасан: 2025 оны 04 дүгээр сарын 15

**Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны эхний 3 дугаар сард 191.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 13.7 (7.7%) тэрбум төгрөгөөр , сангийн зарлага 73.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 51.4 (0.1%) сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.**

**ЗУРАГ 3.** **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сангуудаар, тэрбум төгрөг**

Сангуудаар авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 9.9 (6.9%) тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 1.4 (9.2%) тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 12.7 (19.3%) тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 6.3 (5.2%) тэрбум төгрөгөөр тус өссөн үзүүлэлттэй байна.




**ЗУРАГ 4.** **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар**



**ЗУРАГ 5.** **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сангуудаар, тэрбум төгрөг**




Сангуудын зарлага өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн зарлага 256.5 (0.3%) сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 4.1 (0.1%) сая төгрөгөөр тус тус өссөн бол тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 178.6 (3.3%) тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 30.5 (6.7%) сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

**НИЙГМИЙН ХАЛАМЖ:** Нийгмийн халамжийн сангаас 2026 оны эхний 3 сарын байдлаар 90.5 мянган хүнд 28.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 3.4 (4.0%) мянган хүнээр буурч, олгосон тэтгэмж 751.4 (2.8%) сая төгрөгөөр өссөн байна.

**ХҮСНЭГТ 5.** **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР, сая төгрөг**

| Үйлчилгээний төрөл | Нийгмийн халамжын үйлчилгээ | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | 2025 I-III | 2026 I-III | Тоо | Хувь |
| Нийгмийн халамжын тэтгэвэрт | 2 843.3 | 3 325.7 | 482.4 | 17.0% |
| Нийгмийн халамжын тэтгэмж | 19 913.5 | 19 742.3 | -171.2 | -0.9% |
| Асаргааны тэтгэмж | 2 446.1 | 2 859.2 | 413.1 | 16.9% |
| Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох | 876.8 | 981.2 | 104.4 | 11.9% |
| Алдар цолтон ахмад настанд төрөөс олгох тусламж, хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт, нийгмийн хөгжлийн үйлчилгээ, тэтгэмж | 198.1 | 168.7 | -29.4 | -14.9 |
| Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж | 1 004.2 | 956.3 | -47.9 | -4.8 |
| Нийт | 27 281.9 | 28 033.4 | 751.5 | 2.8 |

Үүнээс, нийгмийн халамжийн тэтгэмжэнд 2026 оны эхний 3 сарын байдлаар 90450 хүн хамрагдаж 28.0 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 3.4 (4.0%), олгосон мөнгөн тэтгэвэр 751.4 (2.8%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2475 хүн хамрагдаж 3.3 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 68 (2.7%), олгосон мөнгөн тэтгэвэр 482.4 (17.0%) сая төгрөгөөр, асаргааны тэтгэмж 413.1 (16.9%) сая, ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох 104.5 (11.9%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Нийгмийн халамжийн тэтгэмж 171.2 (0.9%) сая төгрөг, алдар цолтон ахмад настанд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд төрөөс олгох тусламж хөнгөлөлт 29.4 (14.9%) сая төгрөгөөр, эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж 47.9 (4.8%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

# ГЭМТ ХЭРЭГ

I-XII/2026 Тархаасан: 2026 оны 04 дүгээр сарын 15

## Дүүргийн хэмжээнд нийт 1197 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 187 (18.5%) хэргээр өссөн байна.

2026 оны эхний 3 сард 1197 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 187 (18.5%) хэргээр өссөн үзүүлэлтэй байна.

Гэмт хэргийн улмаас 492 хүн гэмтэж осолдон, 58 хүн нас барж, төр ард иргэдэд 18849.5 сая төгрөгийн хохирол учруулснаас 1692.6 тэрбум (9.0%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

**ЗУРАГ 6.** **БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар**




Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 43.5 хувийг залилан, 16.6 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 16.3 хувийг хулгайн, 0.9 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 4.2 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 2.6 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 2.5 хувийг дээрэм, 0.8 хувийг хүчин, 12.5 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

**ХҮСНЭГТ 6.** **БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 3 сарын байдлаар**

| Төрөл | Гэмт хэргийн тоо | | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | 2024 I-III | 2025 I-III | 2026 I-III | Тоо | Хувь |
| **Дүүргийн дүн** | **803** | **1 010** | **1 197** | **187** | **18.5** |
| Хүний амь | - | - | - | - | - |
| Хүчин | 13 | 8 | 10 | 2 | 25.0 |
| Дээрэм | 11 | 25 | 30 | 5 | 20.0 |
| Хулгай | 168 | 275 | 195 | -80 | -29.1 |
| Залилан | 289 | 293 | 521 | 228 | 77.8 |
| Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 167 | 171 | 199 | 28 | 16.4 |
| Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих | 21 | 51 | 50 | -1 | -2.0 |
| Бусдыг амиа хорлоход хүргэх | 9 | 24 | 31 | 7 | 29.2 |
| Бусдын хөрөнгө ашиглах | 9 | 14 | 11 | -3 | -21.4 |
| Бусад гэмт хэрэг | 116 | 149 | 150 | 1 | 0.7 |

## ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр

| Дүүрэг | Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг | | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | 2024 I-III | 2025 I-III | 2026 I-III | Тоо | Хувь |
| **Нийслэлийн дүн** | **6 524** | **10 270** | **9 969** | **-301** | **-2.9** |
| Багануур | 79 | 138 | 95 | -43 | -31.2 |
| Багахангай | 8 | 7 | 11 | 4 | 57.1 |
| Баянгол | 1 356 | 1 759 | 1 777 | 18 | 1.0 |
| Баянзүрх | 1 170 | 2 876 | 2 350 | -526 | -18.3 |
| Налайх | 105 | 58 | 90 | 32 | 55.2 |
| Сонгинохайрхан | 1 013 | 1 385 | 1 337 | -48 | -3.5 |
| Сүхбаатар | 1 088 | 1 465 | 1 499 | 34 | 2.3 |
| Хан-Уул | 902 | 1 572 | 1 613 | 41 | 2.6 |
| Чингэлтэй | 803 | 1 010 | 1 197 | 187 | 18.5 |

2026 оны эхний 3 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 1055 (88.1%) нь хөнгөн хэрэг, 142 (11.9%) нь хүнд хэрэг байна.

<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

<u>Гэмт хэрэг:</u> Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

<u>16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг:</u> Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

<u>Хохирогч:</u> Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл

мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

<u>Гэмт хэргийн хохирол:</u> Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

<u>Яллагдагч:</u> Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

# ДҮҮРГИЙН ТӨСӨВ

I-XII/2026 Тархаасан: 2026 оны 04 дүгээр сарын 15

## Дүүргийн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 35.6 хувиар буурлаа.

Дүүргийн төсвийн нийт орлого 2026 оны эхний 3 сарын байдлаар 64.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 35.9 (35.6%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна. Төсвийн нийт орлогын 98.1 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 1.6 хувийг татварын бус орлого, 0.3 тусламжийн орлого тус тус эзэлж байна.

2026 оны эхний 3 сарын байдлаар дүүргийн татварын орлого 64.8 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 36.1 (35.8%) тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 1051.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 447.6 (29.9%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна.

**ЗУРАГ 7.** **ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг**




**ХҮСНЭГТ 8.** **ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 оны эхний 3 сарын байдлаар**

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Нийт орлого ба тусламжийн дүн | 100 884.3 | 64 942.9 | -35 941.4 | -35.6% |
| А. Урсгал орлого | 100 884.3 | 64 762.9 | -36 121.4 | -35.8% |
| 1. Татварын орлого | 99 385.0 | 63 711.2 | -35 673.8 | -35.9% |
| 1.1. Орлогын албан татвар | 89 701.3 | 57 036.2 | -32 665.1 | -36.4% |
| 1.2. Өмчийн татвар | 1 562.4 | 1 613.2 | 50.8 | 3.3% |
| 1.3. Бусад татвар (төлбөр хураамж) | 8 121.3 | 5 061.9 | -3 059.4 | -37.7% |
| 2. Татварын бус орлого | 1 499.3 | 1 051.7 | -447.6 | -29.9% |
| Б. Хөрөнгийн орлого | - | - | - | - |
| В. Тусламжийн орлого | - | - | - | - |

**Эх үүсвэр: ЧД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтэс*

Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх дүн 2026 оны эхний 3 сарын байдлаар 43.6 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 41.9 (49.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Төсвийн нийт зарлагын 9.2 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 1.0 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 25.4 хувийг бараа, үйлчилгээний бусад зардал 42.3 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

**ЗУРАГ 8.** **ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг**




**ХҮСНЭГТ 9.** **ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2026 оны эхний 3 сард, сая төгрөг**

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **85 603.0** | **43 645.0** | **-41 958.0** | **-49.0%** |
| А. Урсгал зарлага | 75 989.9 | 34 032.0 | -41 957.9 | -55.2% |
| 1. Бараа, үйлчилгээний зардал | 20 797.0 | 15 557.7 | -5 239.3 | -25.2% |
| 1.1. Цалин, хөлс | 5 654.7 | 4 030.8 | -1 623.9 | -28.7% |
| 1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж | 736.1 | 439.6 | -296.5 | -40.3% |
| 1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал | 14 406.2 | 11 087.3 | -3 319.0 | -23.0% |
| 2. Зээлийн үйлчилгээний төлбөр | - | - | - | - |
| 3. Татаас ба урсгал шилжүүлэг | 55 192.9 | 18 474.2 | -36 718.7 | -66.5% |
| 3.1. Татаас | - | - | - | - |
| 3.2. Урсгал шилжүүлэг | 55 192.9 | 18 474.2 | -36 718.7 | -66.5% |
| Б. Хөрөнгийн зардал | 9 613.0 | 9 613.0 | - | - |
| Хөрөнгө оруулалт | 9 613.0 | 9 613.0 | - | - |

**ЗУРАГ 9.** **ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөг**



Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, ирээдүйн өв сангийн төсөв эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.

# ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 04 дүгээр сарын 15

**Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өслөө.**

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2026 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7.3 хувь, өмнөх сараас 1.5 хувиар өссөн байна.

**ЗУРАГ 10.** **ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, сараар**




Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 2026 оны 3 дугаар сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 2.9 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 8.3 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 2.5 хувь, Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 4.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.1 хувь, тээвэр 1.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 4.8 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

**ХҮСНЭГТ 10.** **ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр**

| Бараа, үйлчилгээний бүлгийн нэр | 2026 III / 2025 III | 2026 III / 2025 XII | 2026 III / 2026 II |
|---|---|---|---|
| Ерөнхий индекс | **7.3** | **2.9** | **1.5** |
| Хүнсний бараа, согтууруулах бус ундаа | 15.3 | 8.3 | 3.2 |
| Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис | 10.0 | 2.5 | 0.0 |
| Хувцас, бөс бараа, гутал | 6.6 | 0.7 | 0.2 |
| Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш | 0.7 | -2.2 | -1.1 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 9.2 | 4.2 | 1.5 |
| Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ | 7.0 | 2.1 | 0.1 |
| Тээвэр | -2.6 | 1.8 | 4.0 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 2.5 | 0.0 | 0.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 7.1 | 0.8 | 0.1 |
| Боловсролын үйлчилгээ | 13.6 | 0.0 | 0.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 9.5 | 4.8 | 0.0 |
| Даатгал, санхүүгийн үйлчилгээ | 1.7 | 0.0 | 0.0 |
| Бусад бараа, үйлчилгээ | 9.9 | 0.8 | 0.3 |

**ЗУРАГ 11.** **ГУРИЛ, ТАЛХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн III сард, төгрөг**




**ЗУРАГ 12.** **ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн III сард, төгрөг**




**ЗУРАГ 13.** **ТӨМС, ЛУУВАНГИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн III сард, төгрөг**



**ЗУРАГ 14.** **ТАРАГ, СҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн III сард, төгрөг**




<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

<u>Хэрэглээний сагс:</u> Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

<u>Хэрэглээний бараа, үйлчилгээний жин:</u> Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

<u>Хэрэглээний үнийн индекс (ХҮИ):</u> Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

<u>Тооцох аргачлал:</u>

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томьёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^{L} = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}}\right)\left(\frac{P_{it-1}}{P_{it-2}}\right)\cdots\left(\frac{P_{i2}}{P_{i1}}\right)\left(\frac{P_{i1}}{P_{i0}}\right)\frac{P_{i0}Q_{i0}}{\sum P_{i0}Q_{i0}}$$

$I_{ct}^{L}$ – t тайлант үеийн Ласдейресийн үнийн индекс
t – Тайлант үе
0 – суурь үе
$p_{t}^{i}$ – i барааны тайлант үеийн үнэ
$p_{0}^{i}$ – i барааны тайлант үеийн үнэ
$q_{0}^{i}$ – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигла

# НИЙТИЙН АЖ АХУЙ

I-XII/2026 Тархаасан: 2026 оны 04 дүгээр сарын 15

**Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2908.5 мян.м² зам талбай цэвэрлэж, 16524.8 тн хог тээвэрлэжээ.**

**ХҮСНЭГТ 11.** **ТОХИЖИЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ, ОРЛОГО 2026 оны 3 дугаар сард**

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2024 III | 2025 III | 2026 III | 2025/2026 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Дүн | Хувь |
| Цэвэрлэсэн талбай | мян.м$^2$ | 2 908.5 | 2 908.5 | 2 908.5 | - | - |
| Тээвэрлэсэн хог | Тн | 21 921.7 | 23 159.1 | 16 524.8 | -6 634.3 | -28.6 |
| Орон сууц | Тн | 3 470.4 | 2 342.2 | 3 562.0 | 1 219.8 | 52.1 |
| Гэр хороолол | тн | 17 967.9 | 20 082.4 | 12 683.4 | -7 399.0 | -36.8 |
| Албан газар | тн | 483.4 | 734.5 | 279.4 | -455.1 | -62.0 |
| Зам талбай | Тн | .0 | .0 | .0 | - | - |
| Ажил үйлчилгээний орлого | сая.төг | 1 258.0 | 2 226.1 | 1 933.5 | -292.6 | -13.1 |
| Зам талбай | сая.төг | 232.1 | 1 142.2 | 1 326.9 | 184.6 | 16.2 |
| Гэр хороолол | сая.төг | 840.9 | 939.9 | 426.9 | -513.0 | -54.6 |
| Орон сууц | сая.төг | 162.4 | 109.6 | 166.7 | 57.1 | 52.1 |
| Албан газар | сая.төг | 22.6 | 34.4 | 13.1 | -21.3 | -61.9 |

**Эх үүсвэр: Найши ХХК, ТҮК*

2026 оны 3 дугаар сард тээвэрлэсэн хог өмнөх жилийн мөн үеэс 6634.3 тн (28.6%) буурсан байна. Ажил үйлчилгээний орлого 1933.5 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 292.6 (13.1%) сая төгрөгөөр буурчээ. Орлогын эх үүсвэрийг ангилбал 22.1 хувийг гэр хороолол, 68.6 хувийг зам талбай, 8.6 хувийг орон сууц, 0.7 хувийг албан газрын цэвэрлэгээ үйлчилгээнээс олсон орлого тус тус эзэлж байна.

# ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

I-XII/2026 Тархаасан: 2026 оны 04 дүгээр сарын 15

**Дүүргийн хэмжээнд нийт 12240 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8574(41.2%) зөрчилөөр буурсан байна.**

Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтсийн алба хаагчид 2026 оны эхний 3 сард гудамж замд хийсэн хяналт шалгалтаар нийт 12240 зөрчил илрүүлсэн. Үүнээс 215 зөрчлийг шалгаж шийдвэрлэсэн. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 263 холбогдогчийг шүүхээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийлгэснээс 263 иргэнийг 1 жил тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 207 хүнд торгож, эрх хасах, 56 хүнийг эрх хасаж, баривчлах шийтгэл оногдуулсан байна.

**ХҮСНЭГТ 12.** **ТОРГУУЛСАН ЖОЛООЧИЙН ТОО, торгуулийн хэмжээ**

| Торгууль | 2024 I-III | 2025 I-III | 2026 I-III |
|---|---|---|---|
| Торгуулсан хүний тоо | 23 526 | 20 814 | 12 240 |
| Торгуулийн нийт хэмжээ /сая төгрөг/ | 374.6 | 501.3 | 353.4 |

**ХҮСНЭГТ 13.** **ЗАМ ТЭЭВРИЙН ЗӨРЧИЛ, зөрчлийн хэлбэрээр**

| Зөрчлийн хэлбэр | 2024 I-III | 2025 I-III | 2026 I-III |
|---|---|---|---|
| НИЙТ ЗӨРЧИЛ | 23 526 | 20 814 | 12 240 |
| Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон | 241 | 246 | 263 |
| Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, боловч тээврийн хэрэгсэл жолоодсон | 227 | 275 | 391 |
| Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон | 1 755 | 1 789 | 1 645 |
| Хамгаалах бүс хэрэглээгүй | 1 364 | 2 420 | 1 883 |
| Хориглосон нөхцөлөөр зогссон | 5 904 | 2 751 | 149 |
| Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн | 6 | 3 | 25 |
| Эгнээ байраа буруу эзэлсэн | 770 | 508 | 783 |
| Бусад зөрчил | 13 259 | 12 822 | 7 101 |

**Эх үүсвэр: ЧД-ийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтэс*

# ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

I-XII/2026 Тархаасан: 2026 оны 04 дүгээр сарын 15

**2026 оны эхний 3 сард иргэний бүртгэлийн 9 төрлийн үйлчилгээг 16309 удаа үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1846 (10.2%) хүнээр буурсан үзүүлэлттэй байна.**

**ХҮСНЭГТ 14.** **ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХҮНИЙ ТОО, үйлчилгээний төрлөөр**

| Үзүүлэлт | 2025 I-III | 2026 I-III | 2025/2026 | |
|---|---|---|---|---|
| | Дүнгээр | | Дүн | Хувь |
| **Нийт** | **18 155** | **16 309** | **- 1 846** | **-10.2** |
| Шинэ төрсөн | 561 | 505 | - 56 | -10.0 |
| Гэрлэлт | 137 | 121 | - 16 | -11.7 |
| Гэр бүл цуцлалт | 74 | 62 | - 12 | -16.2 |
| Хүүхэд үрчлэлт | 12 | 10 | - 2 | -16.7 |
| Эцэг тогтоосон | 30 | 15 | - 15 | -50.0 |
| Овог, нэр өөрчлөх | 31 | 23 | - 8 | -25.8 |
| Шилжин ирсэн | 1 135 | 961 | - 174 | -15.3 |
| Лавлагаа | 12 922 | 11 836 | - 1 086 | -8.4 |
| Иргэний үнэмлэх олголт: | 3 253 | 2 776 | - 477 | -14.7 |
| 16 нас хүрч шинээр авсан | 649 | 728 | 79 | 12. 2 |
| Дахин олголт | 2 594 | 2 048 | - 546 | -21.0 |

** Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс*

<u>Онцгой байдал</u>:

Аюулт үзэгдэл, ослын дуудлага 2026 оны эхний 3 сард 138 удаа бүртгэгдэж, өмнөх оноос 2 (1.5%)-аар нэмэгдсэн байна. Тохиолдсон аюулт үзэгдэл, Ахуйн 100 гал түймэр гарч, өмнөх оны мөн үеэс 3 (2.9%)-аар буурсан бөгөөд гал түймрийн аюулаас 8 хүн, 8.8 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг аварсан байна.

**ХҮСНЭГТ 15. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, жил бүрийн эхний 3 сард**

| Үзүүлэлтүүд | 2024 I-III | 2025 I-III | 2026 I-III | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| Дуудлагын тоо | 99 | 136 | 138 | 2 | 1.5 |
| Худал дуудлага | 4 | 2 | 3 | 1 | 50.0 |
| Гал түймрийн тохиолдлын тоо | 70 | 103 | 100 | -3 | -2.9 |
| Унтраасан гал түймрийн тоо | 81 | 102 | 83 | -19 | -18.6 |
| Ашигласан ус, тонн | 293.5 | 491.0 | 174.2 | -316.8 | -64.5 |
| Ашигласан шатахуун /дизель/, литр | 2 268.9 | 2 501.0 | 1 782.8 | -718.2 | -28.7 |
| Ашигласан хөөс, литр | 0.0 | 379.0 | 0.0 | -379.0 | -100.0 |
| Зарцуулсан хөрөнгө, сая.төг | 25.9 | 4.4 | 4.8 | 0.4 | 9.1 |
| Аварсан хүний тоо | 236 | 540 | 8 | -532 | -98.5 |
| Учирсан хохирол, сая.төг | 9 433.0 | 9 802.0 | 8 770.0 | -1 032.0 | -10.5 |

[1]-дахин их * *Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтсийн галын мэдээ*

**ЗУРАГ 16. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, жил бүрийн эхний 3 сард**



**Эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ:**

2026 оны 3 дугаар сарын байдлаар 7 төрлийн үйлчилгээг нийт 1520 удаа иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлж, үйлчилгээний хөлсөнд 36921.0 сая төгрөгийн хураамж авсан байна.

**ХҮСНЭГТ 16.** **ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО, төрлөөр**

| Үйлчилгээний төрөл | 2026 III сар | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Эд хөрөнгийн бүртгэл | | Газар | | Газраас бусад | |
| | Үйлчилгээний тоо | Үйлчилгээний хөлс (сая.төг) | Үйлчилгээний тоо | Үйлчилгээний хөлс (сая.төг) | Үйлчилгээний тоо | Үйлчилгээний хөлс (сая.төг) |
| Нийт | 1 520 | 36 921 | 506 | 7 236 | 1 014 | 29 685 |
| Анхны бүртгэл | 119 | 113 | 19 | 80 | 100 | 33 |
| Өмчлөх эрх шилжих гэрээ | 297 | 5 964 | 96 | 1 936 | 201 | 4 028 |
| Барьцааны гэрээ | 982 | 29 865 | 333 | 4 796 | 649 | 25 069 |
| Бусад гэрээ | 4 | 30 | - | - | 4 | 30 |
| Бүртгэлд өөрчлөлт оруулах | 84 | 904 | 44 | 416 | 40 | 488 |
| Урьдчилсан тэмдэглэл | 3 | 5 | 1 | - | 2 | 5 |
| Лавлагаа хуулбар | 31 | 40 | 13 | 8 | 18 | 32 |

**Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс*

<u>Улаан загалмай:</u> 2026 оны эхний 3 сард 6732 хүнд 4650 мянган төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь хамрагдсан хүний тоо өмнөх оны мөн үеийнхээс 251 (3.6%) хүнээр, зарцуулсан зардал 40 (0.9%) мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

**ХҮСНЭГТ 17.** **ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, төрлөөр эхний 3 сард**

| Үзүүлэлт | 2025 I-III | | | 2026 I-III | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хэдэн удаа | Хамрагдсан хүний тоо | Зардал /мян.төг/ | Хэдэн удаа | Хамрагдсан хүний тоо | Зардал /мян.төг/ |
| Дүн | 165 | 6 983 | 4 690 | 106 | 6 732 | 4 650 |
| Халамж үйлчилгээ | 12 | 261 | 910 | 11 | 57 | 140 |
| Халамжийн чиглэлээрх сургалт, сурталчилгаа | 29 | 847 | 1020 | 5 | 61 | 700 |
| Анхны тусламжийн сургалт | 11 | 376 | 230 | 12 | 243 | 250 |
| Эрүүл мэндийг дэмжих сургалт, сурталчилгаа | 5 | 80 | 50 | 8 | 557 | 918 |
| Гамшгийн тусламж | - | - | - | - | - | - |
| Гамшгийн талаарх сургалт, сурталчилгаа | 9 | 2 158 | 750 | 5 | 2 821 | 770 |
| Донорын өдөрлөг, сурталчилгаа | 8 | 298 | - | 5 | 141 | 62 |
| Хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээрх сургалт, сурталчилгаа | 25 | 886 | 1310 | 18 | 1 016 | 1 460 |
| Хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7 зарчим, ТУЗХА-ны сурталчилгаа | 66 | 2 077 | 420 | 42 | 1 836 | 350 |

**Эх үүсвэр: Улаан загалмайн хороо*

**Захиргааны мэдээлэл:** Иргэдээс 2026 оны эхний 3 сард 876 өргөдөл, гомдол ирсэн нь өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар өсчээ.

**ХҮСНЭГТ 18. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ, хүлээн авсан нэгжийн ангиллаар, 2026 оны эхний 3 сард**

| Ангилал | 2025 I-III | 2026 I-III | Үүнээс: | |
|---|---|---|---|---|
| | | | Шийдвэрлэх шатандаа байгаа | Шийдвэрлэж хариу өгсөн |
| **Нийт** | 818 | 876 | 202 | 674 |
| Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв | 9 | 3 | - | 3 |
| Нутгийн захиргааны байгууллагууд | 465 | 538 | 132 | 406 |
| 1800-1200 дугаарын оператор | 38 | 35 | 7 | 28 |
| 11-11 төвөөс ирсэн | 302 | 287 | 61 | 226 |
| Гар утасны аппликэйшнээр ирсэн | | - | - | - |
| Мессеж | | - | - | - |
| E-Service | 2 | 7 | 1 | 6 |
| Facebook | | - | - | - |
| Дижитал сити | | 6 | 1 | 5 |
| Хороо бүртгэсэн | 2 | - | - | - |
| Smartcar3.0 | | - | - | - |
| НМХГ тусгай дугаар | | - | - | - |

**Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс*

Иргэдээс 2026 оны эхний 3 сард 876 өргөдөл, гомдол ирснээс 674 (76.9%)-ыг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж, 202 (23.1%) нь шийдвэрлэх шатандаа хянагдаж байна.

# АЖ ҮЙЛДВЭР

I-XII/2026 — Тархаасан: 2026 оны 04 дүгээр сарын 15

## Дүүргийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 6.6 дахин өслөө

Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны эхний 3 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 171.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 145.9 (6.6 дахин) тэрбум төгрөгреөр өслөө. Үүнд: уул уурхайн олборлолт 156.8 тэрбум төгрөгөөр өссөн бол боловсруулах үйлдвэрлэл 13.9 (39.0%) тэрбум төгрөг, ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 1.2 (53.3%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

**ХҮСНЭГТ 19.** **АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар**

| Салбар | Нийт үйлдвэрлэлт | | | 2026* III / 2025 III |
|---|---|---|---|---|
| | 2024 I-III | 2025 I-III | 2026* I-III | |
| | сая төгрөг | | | Хувь |
| БҮГД | 27 479.4 | 26 007.2 | 171 938.2 | 6.6** |
| УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ | 2 238.1 | 515.4 | 156 756.8 | |
| Чулуун, хүрэн нүүрс олборлолт | 366.2 | 0.0 | 0.0 | |
| Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт | 0.0 | 0.0 | 0.0 | |
| Металлын хүдэр олборлолт | 171.5 | 0.0 | 154 931.9 | |
| Бусад ашигт малтмал олборлолт | 142.2 | 0.0 | 0.0 | |
| Уул уурхайн туслах үйл ажиллагаа | 1 558.2 | 515.4 | 1 824.9 | 3.5** |
| БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ | 22 820.2 | 22 845.0 | 13 944.8 | - 39.0 |
| Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл | 5 614.8 | 13 354.7 | 3 548.8 | - 73.4 |
| Мах боловсруулах, консервлох | 4 175.0 | 11 815.6 | 142.5 | - 98.8 |
| Ундаа үйлдвэрлэл | 1 439.8 | 1 539.1 | 3 406.3 | 2.2** |
| Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл | 8 739.6 | 1 329.0 | 1 815.3 | 36.3 |
| Хувцас үйлдвэрлэл | 1 403.9 | 2 722.2 | 5 094.8 | 87.2 |
| Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл | 48.9 | 60.8 | 0.0 | - 100.0 |
| Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 3 780.7 | 4 293.4 | 1 542.4 | - 64.1 |
| Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа | 1 188.3 | 544.6 | 643.4 | 18.1 |
| Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл | 368.9 | 360.4 | 1 158.9 | 3.2** |
| Тавилга үйлдвэрлэл | 1 518.0 | 23.8 | 0.0 | - 100.0 |
| Бусад боловсруулах үйлдвэрлэл | 157.0 | 156.1 | 141.4 | - 9.4 |
| УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | 2 421.1 | 2 646.7 | 1 236.5 | - 53.3 |
| Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах | 2 421.1 | 2 646.7 | 1 236.5 | - 53.3 |

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны эхний 3 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 171.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 145.9 (6.6 дахин) тэрбум төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолт 154.9 тэрбум төгрөгөөр, уул уурхайн туслах үйл ажиллагаа 1.8 (3.5 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны эхний 3 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 13.9 тэрбум төгрөг

болж, өмнөх оны мөн үеэс 8.9 (39.0%) тэрбум төгрөгөөр буурахад хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл 9.8 (73.4%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 2026 оны эхний 3 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4 (53.3%) тэрбум төгрөгөөр буурахад хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах, дахин ашиглах 1.4 (53.3%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийслэлийн аж үйлдвэрийн салбар 2026 оны эхний 3 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 93.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 94.3 хувийг, боловсруулах аж үйлдвэрлэл 5.2 хувийг, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 0.5 хувийг тус тус эзэлж байна.

**ЗУРАГ 17.** АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, жил бүрийн эхний 3 сард







Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2026 оны эхний 3 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 174.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 145.6 (6.1 дахин) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд: уул уурхай, олборлолтын салбарын борлуулалт 157.0 тэрбум төгрөгөөр өссөн бол боловсруулах үйлдвэрлэл 10.1 (41.1%) тэрбум төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа салбарын борлуулалт 1.3 (48.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. Гадаад зах зээлд 2026 оны эхний 3 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 244.2 сая төгрөгийн борлуулалт хийсний 244.2 сая төгрөг нь боловсруулах үйлдвэрийн салбарын борлуулалт байна.

## ХҮСНЭГТ 20. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

| Салбар | Нийт борлуулалт | | | 2026* III / 2025 III | Экспорт |
|---|---|---|---|---|---|
| | 2024 III | 2025 III | 2026* III | | |
| | сая төгрөг | | | Хувь | |
| БҮГД | 29 710.3 | 28 435.8 | 174 096.6 | 6.1** | 0.1 |
| УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ | 2 403.2 | 1 219.2 | 158 253.4 | | |
| Чулуун, хүрэн нүүрс олборлолт | 490.4 | 703.8 | 418.9 | -40.5 | |
| Металлын хүдэр олборлолт | 171.5 | .0 | 154 931.9 | | |
| Уул уурхайн туслах үйл ажиллагаа | 183.1 | .0 | 1 077.7 | | |
| БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ | 1 558.2 | 515.4 | 1 824.9 | 3.5** | |
| Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл | 24 886.1 | 24 569.8 | 14 483.0 | -41.1 | 1.7 |
| Мах боловсруулах, консервлох | 7 619.3 | 15 451.5 | 3 369.7 | -78.2 | 4.2 |
| Ундаа үйлдвэрлэл | 6 179.5 | 12 062.4 | 142.5 | -98.8 | 1.0** |
| Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл | 1 439.8 | 3 389.0 | 3 227.3 | -4.8 | |
| Хувцас үйлдвэрлэл | 9 187.8 | 1 752.1 | 1 966.5 | 12.2 | 5.2 |
| Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл | 1 359.6 | 1 916.6 | 5 522.0 | 2.9** | |
| Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | | | | | |
| Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа | 3 780.7 | 4 293.4 | 1 542.4 | -64.1 | |
| Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл | 1 198.6 | 552.8 | 768.0 | 38.9 | |
| Тавилга үйлдвэрлэл | 80.3 | 360.4 | 1 158.9 | 3.2** | |
| Бусад боловсруулах үйлдвэрлэл | 1 437.7 | 23.8 | .0 | -100.0 | |
| УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | 157.0 | 156.1 | 155.5 | -0.4 | |
| Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах | 2 421.1 | 2 646.7 | 1 360.2 | -48.6 | |

## ЗУРАГ 18. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ, жилийн бүрийн эхний 3 сард



# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

I-XII/2026 Тархаасан: 2026 оны 04 дүгээр сарын 15

**Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр тус хэлтэст ажил хайж бүртгүүлсэн нийт 260 иргэн байна.**

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр тус хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэдийн тоо 2026 оны эхний 3 сард 260 иргэн бүртгэгдсэн байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 128 (49.2%) нь эмэгтэйчүүд байна.

**ЗУРАГ 19.** ДҮҮРГИЙН БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр хувиар




Насны бүлгээр авч үзвэл бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 8 (1.3%) нь 15-24 насны, 53 (28.1%) нь 25-34 насны, 90 (28.1%) нь 35-44 насны, 83 (20.2%) нь 45-54 насны, 26 (14.5%) 55-аас дээш насны хүмүүс байна.

**ЗУРАГ 20.** БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшинээр эхний 3 сарын байдлаар



# БҮЛЭГ

**ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:**

| | | |
|---|---|---|
| | Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2023-2025 он | |
| | Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр | Г. Пүрэвсүрэн |
| I | Эрүүл мэнд | Б.Мишээлт |
| II | Нийгмийн даатгал, халамж | Н.Халиун |
| III | Гэмт хэрэг | Г. Пүрэвсүрэн |
| IV | Төсөв | Г. Пүрэвсүрэн |
| V | Хэрэглээний үнэ | Л. Шинэтуяа |
| VI | Нийтийн аж ахуй | Л. Шинэтуяа |
| VII | Дүүргийн аюулгүй байдал | Г. Пүрэвсүрэн |
| VIII | Төрийн үйлчилгээ | Б. Мишээлт<br>Л. Шинэтуяа |
| IX | Аж үйлдвэр | Н.Халиун |
| X | Хөдөлмөр | Г. Пүрэвсүрэн |

Танилцуулга хянасан хэлтсийн дарга: ................................ /Д.МӨНХЗУЛ/

Танилцуулгыг нэгтгэсэн мэргэжилтэн: .............................. /Б.МИШЭЭЛТ/

Авлигатай
тэмцэх газар

**Хэрэв танд:**

-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл;

-Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан "Авлигын гэмт хэрэг"-ийн шинжтэй гомдол мэдээлэл өгөхөөр бол Авлигатай тэмцэх газарт хандана уу:

**Үүнд:**

22.1 дүгээр зүйл */Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/;*
22.3 дугаар зүйл */Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/;*
22.4 дүгээр зүйл */Нийтийн албан тушаалтан хахууль авах/;*
22.5 дугаар зүйл */Хахууль өгөх/;*
22.6 дугаар зүйл */Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/;*
22.7 дугаар зүйл */Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/;*
22.8 дугаар зүйл */Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;*
22.9 дүгээр зүйл */Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;*
22.10 дугаар зүйл */Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/;*
22.11 дүгээр зүйл */Дураараа аашлах/;*
22.12 дугаар зүйл */Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/;*
22.13 дугаар зүйл */Хахууль авах/;*

**ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО /ХҮСНЭГТЭЭР ХАРУУЛБАЛ/**




**110**
Авлигыг мэдээлэх утас

**ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ**
Хүлээн авах суваг

Авлигатай тэмцэх газарт ирж биечлэн
**Утсаар:** (976)-110 /Ярианы төлбөргүй/ дугаараар
**Факс:** (976)-11-311919
**Цахим шуудангийн хаяг:** contact@iaac.mn
**Шуудан холбоогоор:** Улаанбаатар хот 14250, Сүхбаатар дүүрэг, 5 хороолол, Сөүлийн гудамж 41 хаягаар
**Веб сайт:** iaac.mn

Авлигын эсрэг НЭГДЬЕ

www.ubstat.mn

www.1212.mn

## ХОЛБОО БАРИХ

Хаяг: Нийслэлийн нутгийн
захиргааны байгууллагын "Б" барилга, 4 давхар
Арцатын ам,
Наадамчдын зам 1200

Утас: +(976)-11-328787
+(976)-11-327946
+(976)-11-322783
и-мэйл: ulaanbaatar@nso.mn